



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУШААЛ**

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/352

Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах тухай**


Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3, 11.10, ШУТИС-ийн дүрмийн 4.4, 4.9.15, 4.9.16 дахь заалт, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1 “ШУТИС-ийн Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2 “ШУТИС-ийн Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг мөрдөж хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Н.Эрдэнэхүү), захиргааны холбогдох нэгж, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн удирдлагад үүрэг болгосугай.


3 Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “ШУТИС-ийн Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай” А/173, ШУТИС-ийн Захирлын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/169 дугаартай тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

РЕКТОР



Т.НАМНАН

ШУТИС-ийн ректорын 2025 оны 11 дүгээр сарын 06 өдрийн 1392 дугаар тушаалын хавсралт

	<b>ШУТИС-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ</b> ШУТИС-СУ-ЖУ01	Эхний хэвлэлт	2014.05.06
		Өөрчилсөн огноо	2025.11.06
		Өөрчлөлтийн дугаар	5

# ШУТИС-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

ШУТИС-ийн ректорын 2025 оны 11 дүгээр сарын 06 өдрийн 159 дугаар тушаалын хавсралт



## АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	3
ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ГУРАВ.НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ.НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ .....	3
ТАВ.ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН .....	4
ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ .....	5
ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	7
НАЙМ.ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ.....	11
ЕС.БУСАД ЗҮЙЛ .....	11



### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журам нь хөтөлбөрийн хорооны бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагаа болон сургалтын хөтөлбөртэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хөтөлбөрийн хороо нь бүх шатны сургалтын хөтөлбөрийн талаар баримтлах бодлого, заавар, зөвлөмж, шаардлага боловсруулах, хөтөлбөр шинээр нээх, хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэлт, хүрсэн үр дүнд хийсэн чанарын үнэлгээг үндэслэн хөтөлбөрийг шинэчлэх, түр зогсоох, хаах, сэргээх эсэх талаар санал дүгнэлт, шийдвэр гаргана.
- 1.3. Хөтөлбөрийн хороо нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, уламжлал, шинэчлэл, тогтвортой хөгжлийг хангах, шинжлэх ухаанч, мэргэжлийн байр сууринаас хандах, бие даасан, хараат бус, ил тод нээлттэй байх зарчмыг баримтална.

### ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Хөтөлбөрийн ерөнхий хороо, хөтөлбөрийн дэд хороо, хөтөлбөр хэрэгжүүлэх сургууль, нэгжүүдэд хамаарна.

### ГУРАВ.НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1. Боловсролын ерөнхий хууль
- 3.2. Дээд боловсролын тухай хууль
- 3.3. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага
- 3.4. Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн нэр/, индекс
- 3.5. ШУТИС-ийн дүрэм
- 3.6. ШУТИС-ийн эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журам
- 3.7. ШУТИС-ийн Мэргэжлийн тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам
- 3.8. ШУТИС-ийн "Профессор, багшийн ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам"
- 3.9. ШУТИС-ийн Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- 3.10. ШУТИС-ийн ахисан түвшний сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журам

### ДӨРӨВ.НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. **Хөтөлбөрийн ерөнхий хороо (ХЕХ):** Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичгийн хүрээнд ШУТИС-ийн бүх шатны сургалтын хөтөлбөрийн талаар баримтлах бодлого, стандарт шаардлагыг тодорхойлох, хөтөлбөрт хамаарах заавар зөвлөмж, шаардлага, удирдамж боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт, үнэлгээ, зохицуулалтын чиглэлээр шийдвэр гаргах чиг үүрэг бүхий байнгын үйл ажиллагаатай бүтэц;
- 4.2. **Хөтөлбөрийн дэд хороо (ХДХ):** Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль болон бусад зэргийн сургалт эрхэлж буй нэгжийн түвшинд сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг хянах, үнэлэх, холбогдох шийдвэр гаргах, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий байнгын үйл ажиллагаатай бүтэц;
- 4.3. **Мэргэжлийн тэнхим (цаашид тэнхим гэх):** Шинжлэх ухааны тодорхой салбараар төрөлжсөн, мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалавр,



- магистр, докторын хөтөлбөрүүдийг эрхлэн хэрэгжүүлдэг, их сургуулийн хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг эрхлэх нэгжийг;
- 4.4. **Сургалтын хөтөлбөр:** Хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага төлөвшил, сургалтын арга зүй, үнэлгээ сайжруулалтын төлөвлөлт болон сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, багшлах бүрэлдэхүүн, элсэгч, төгсөгчид тавигдах шаардлагыг тусгасан цогц баримт бичгийг;
- 4.5. **Сургалтын төлөвлөгөө:** Хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл болон судлах хичээлийн код, нэр, харгалзах багц цаг, өмнөх холбоо, улирал зэрэг мэдээллийг агуулсан баримт бичгийг;
- 4.6. **Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл (БМИУЗ):** Хөтөлбөрийн магадлан итгэмжлэх шалгуур, шаардлагын дагуу хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийх үндэсний боловсролын холбоо.

### ТАВ.ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

- 5.1. Хөтөлбөрийн хорооны ерөнхий бүтэц
- 5.1.1. ШУТИС-ийн хөтөлбөрийн хороо нь бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль болон бусад зэргийн сургалт эрхэлж буй нэгжид хөтөлбөрийн дэд хороо, их сургуулийн хэмжээнд хөтөлбөрийн ерөнхий хороо гэсэн шаталсан бүтэцтэй байна.
- 5.1.2. Салбар дундын болон дотоодын их сургууль, коллежтой хамтарсан, окутан солилцооны хөтөлбөрийн асуудлыг шийдвэрлэх тохиолдолд хөтөлбөрийн хороод хамтарч үйл ажиллагаа явуулна.
- 5.2. Хөтөлбөрийн хорооны гишүүнд тавигдах нийтлэг шаардлага
- 5.2.1. Хөтөлбөрийн ерөнхий хороо болон дэд хорооны гишүүн нь дээд боловсролын бодлого, их сургууль, шинжлэх ухааны байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн бүтэц зохион байгуулалт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын чиглэлээр зохих мэдлэг, чадвартай, их сургуульд 3-аас доошгүй жил ажилласан, ахлах багш ба түүнээс дээш албан тушаалын зэрэглэлд ажилладаг үндсэн багш болон ажилтан байна.
- 5.2.2. Ажил олгогчийн төлөөлөл нь магистраас доошгүй зэрэгтэй, төр эсвэл хувийн хэвшилд ажилладаг иргэн байна.
- 5.2.3. Төгсөгчдийн төлөөллийг ШУТИС-д ажил эрхэлдэггүй төгсөгчдөөс сонгоно.
- 5.2.4. Хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүд 90 хувь, дэд хорооны гишүүдийн 75 хувиас доошгүй нь докторын зэрэгтэй байна.
- 5.3. Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн
- 5.3.1. Хөтөлбөрийн хороо нь дарга, ахлагч, нарийн бичиг, гишүүдээс бүрдсэн орон тооны бус бүрэлдэхүүнтэй байна.
- 5.3.2. Хөтөлбөрийн хорооны гишүүнийг ШУТИС-ийн ректорын тушаалаар томилно.
- Хөтөлбөрийн дэд хороо:
- 5.3.3. Хөтөлбөрийн дэд хороо нь тухайн сургууль, нэгжийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн тооноос хамаарч ажил олгогч эсвэл төгсөгчийн төлөөллийг



оролцуулан 9 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байх ба хөтөлбөрийн дэд хорооны ахлагч нь сургалт эрхэлсэн нэгжийн дарга байна.

- 5.3.4. Тэнхим, нэгжээс дэвшүүлсэн гишүүд, нарийн бичгийг сургууль, нэгжийн захирлын зөвлөлийн хурлаас сонгоно.
- 5.3.5. Багшлах бүрэлдэхүүний нөөцөөс хамаарч зарим сургууль, нэгж хамтран хөтөлбөрийн дэд хороо байгуулж болно.

Хөтөлбөрийн ерөнхий хороо:

- 5.3.6. ШУТИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 21 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна.
  - 5.3.7. Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга нь ШУТИС-ийн сургалтын асуудал эрхэлсэн проректор, нарийн бичгийн дарга нь сургалт хариуцсан захиргааны нэгжийн дарга байна.
  - 5.3.8. ШУТИС-ийн эрдмийн зөвлөлийн дэргэдэх сургалт, оюутны хөгжил эрхэлсэн дэд зөвлөлөөс гишүүдийн саналаар 3 хүртэл хүнийг, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль болон бусад зэргийн сургалт эрхэлж буй нэгжээс тус бүр нэг хүнийг зөвлөл, сургууль, нэгжийн саналаар хөтөлбөрийн ерөнхий хороонд томилон ажиллуулна.
  - 5.3.9. Хөтөлбөрийн ерөнхий хороо ба дэд хорооны ажлын уялдааг хангах зорилгоор ерөнхий хороо гишүүнийг дэд хорооны бүрэлдэхүүнээс сонгож болно.
  - 5.3.10. ШУТИС-ийн бүх шатны сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх зорилгоор хөтөлбөрийн ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг профессор, багш нараар түр өргөтгөн зохион байгуулж болно.
- 5.4. Хөтөлбөрийн хорооны гишүүнийг 3 жил хүртэл хугацаагаар ажиллуулах ба хорооны гишүүний ажлын тайлан, үзүүлэлтийг харгалзан улируулан сонгож болно.

### **ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ**

- 6.1. Хөтөлбөрийн ерөнхий хорооны чиг үүрэг
  - 6.1.1. Төрөөс боловсролын талаар баримталж буй бодлого, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, ШУТИС-ийн стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийн талаар баримтлах бодлого, бүх шатны сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага болон сургалтын хөтөлбөрийн чиглэлээр холбогдох удирдамж, загвар, заавар, зөвлөмж боловсруулж батлан, хэрэгжилтэд хяналт тавина.
  - 6.1.2. Их сургуулийн хэмжээнд мөрдөх бакалаврын ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээл, магистр, докторын мэргэжлийн суурь хичээлийн цөм агуулгад тавих шаардлагыг баталж, хичээл заах сургууль, тэнхим, багш нарын оролцоог хөтөлбөр, мэргэжлийн онцлог, шинжлэх ухааны шаардлагатай уялдуулан тогтооно.
  - 6.1.3. Сургалтын хөтөлбөр батлах, шинээр нээх, өөрчлөлт оруулах, түр зогсоох, хаах болон сэргээх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэж, ректорын тушаалаар баталгаажуулна.



- 6.1.4. ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт хүрсэн үр дүнд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлын удирдамж, заавар боловсруулж, хэрэгжүүлсэн үнэлгээний үр дүнг хэлэлцэнэ.
  - 6.1.5. Салбар дундын, хавсарга, гадаад, дотоодын их сургууль, коллежтой хамтарсан болон 6 сараас дээш хугацаатай оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
  - 6.1.6. Хөтөлбөрийн дэд хороодын үйл ажиллагаа, хоорондын уялдаа холбоонд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангана.
  - 6.1.7. Бакалавр, магистр, докторын түвшний хөтөлбөр хоорондын уялдааг хангах, нэгдмэл агуулгатай хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
  - 6.1.8. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль болон бусад зэргийн сургалт эрхэлж буй нэгжид хэрэгжүүлж байгаа ижил нэр, индекс бүхий хөтөлбөрийн үндсэн харьяаллыг тогтоож, холбогдох зохицуулалт хийнэ.
- 6.2. Хөтөлбөрийн дэд хорооны чиг үүрэг
- 6.2.1. Хөтөлбөрийн ерөнхий хорооны баталсан эрх зүйн баримт бичгүүд болон холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
  - 6.2.2. Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимээс ирүүлсэн хөтөлбөр шинээр нээх, өөрчлөлт оруулах, түр зогсоох, хаах, сэргээх зэрэг хөтөлбөртэй холбоотой асуудлыг хүлээн авч хэлэлцэн, дүгнэлт гаргана.
  - 6.2.3. Тэнхим, нэгжийн хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, чанарын баталгаажуулалтын чиглэлээр урт хугацааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
  - 6.2.4. Сургалтын хөтөлбөрийн зарим бүрэлдэхүүн хэсэгт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн, сургалт хариуцсан нэгжтэй зөвшилцөн шийдвэрлэнэ.
  - 6.2.5. Сургууль, нэгжийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөр хоорондын уялдаа, хөтөлбөрийн цөм агуулгын хэрэгжилтийг хангах, чанарын баталгаажуулалтын зорилгоор хөтөлбөрт үнэлгээ хийж санал, зөвлөмж гаргана.
  - 6.2.6. Тэнхим, нэгжийн сургалтын хөтөлбөрт хийсэн өөрийн үнэлгээний тайланг хэлэлцэн санал, зөвлөмж гаргана.
  - 6.2.7. Бакалавр ба магистр, магистр ба докторын түвшний суралцагчийн хамт судлах боломжтой хичээлийг тодорхойлох, хөтөлбөр хооронд сургалтын кредит дүйцүүлэх, тооцох асуудлаар санал боловсруулж, сургалт хариуцсан захиргааны нэгжид хүргүүлэн шийдвэрлүүлнэ.
  - 6.2.8. Тэнхим, нэгжээс зааж буй хичээлийн хөтөлбөр түүний суралцахуйн үр дүн, агуулга, заах арга зүй, үнэлгээ болон хичээл хоорондын уялдаа холбоо, давхцалд шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.
  - 6.2.9. Заахуйн болон суралцахуйн шинэ заах арга зүй нэвтрүүлэх чиглэлээр заавар, зөвлөмж гаргана.
  - 6.2.10. Тэнхим, нэгжээс ирүүлсэн сургалтын хөтөлбөр, хичээлийн хэрэгжүүлэх хэлбэр (танхим, цахим, цахим-танхим хосолсон, гадаад хэлээр гэх мэт)-ийг тогтоох саналыг хэлэлцэн, шийдвэрийг сургалт хариуцсан захиргааны нэгжид хүргүүлнэ.
  - 6.2.11. Сургалтын хөтөлбөртэй холбоотой оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, тайланд дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийг сайжруулах талаар зөвлөмж гарган, хэрэгжилтийг хянана.